



ТОГТВОРТОЙ НООС НООЛУУРЫН ЭВСЭЛ

**2021 ОНД МОНГОЛД ХЭРЭГЖИХ
МӨШГӨЛТИЙН ТОГТОЛЦООНЫ ТУХАЙ ГАРЫН АВЛАГА**

АНХААРАХ ЗҮЙЛ:

Энэхүү гарын авлага нь 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөх бөгөөд 2021 онд ТННЭ-ийн баталгаажсан ноолуур худалдан авах, боловсруулах, үйлдвэрлэх компаниудад зориулагдав

АГУУЛГА



1. ТАНИЛЦУУЛГА	3
Мөшгөлт хийх гарын авлага	3
2. ТННЭ-ИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ	4
Бэлтгэн нийлүүлэгч малчны байгууллага	4
Анхан шатны боловсруулах үйлдвэр	4
3. МӨШГӨЛТӨНД ОРОЛЦОХ ШАЛГУУР	5
4. ТННЭ-ИЙН МӨШГӨХ ТОГТОЛЦОО	6
Борлуулалтын баримт	7
Борлуулалтын гэрчилгээ	7
Бүртгэл хөтлөх	7
5. МЭДЭГДЭЛ ГАРГАХ	8
6. ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА	9
Бичиг баримт хөтлөх, ажилчдын сургалт, бусад үүрэг хариуцлага	9
Түүхий эд оролтын бүртгэл	10
Түүхий эд гаралтын бүртгэл	10
7. “SFA CERTIFIED” МЭДЭГДЭЛ, ШОШГО, ЛОГО	11
8. ХАВСРАЛТ	12
ТННЭ-ийн Монгол дахь багтай холбоо барих мэдээлэл	12
Борлуулалтын баримт	13
Борлуулалтын гэрчилгээ	14

1. ТАНИЛЦУУЛГА



1.1. Мөшгөлт хийх гарын авлага

Энэхүү гарын авлагад ТННЭ-ийн 2021 оны мөшгөлт хийх гарын авлагад ТННЭ-ийн баталгаажсан ноолуурын арилжаа хийх, баталгаажсан бүтээгдэхүүн худалдах, худалдан авах компаниудад тавигдах шаардлагуудыг тодорхойлсон болно. Уг гарын авлагыг 2020 оны мөшгөлтийн тогтолцооны туршилтын төсөл дээр үндэслэн шинэчлэн боловсруулсан.

2021 онд бид **Багцаар ангилан хяналттай холих мөшгөлтийн загварыг** үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болно. Энэхүү загвар ёсоор баталгаажсан ноолуурыг бусад ноолууртай хольж болохоор заасан шат дамжлага хүртэл баталгаажсан ноолуурыг ангилан тусгаарлах юм. Баталгаажсан ноолуурыг баталгаажаагүй ноолууртай холих явцыг бүрэн хянан баримтжуулсан байх шаардлагатай бөгөөд эцсийн бүтээгдэхүүн дахь баталгаажсан ноолуурын хувь хэмжээ мэдэгдэж байх ёстой. Үйлдвэрлэлийн шат дамжлага энэхүү мөшгөлтийн загварын дагуу явснаар эцсийн бүтээгдэхүүн дахь баталгаажсан ноолуурыг заасан хувь хэмжээнд барин эцсийн бүтээгдэхүүн дэх ноолуурт өгөх баталгаа болж чаддаг.

Бид 2021 онд нэгж бүтээгдэхүүнд ТННЭ-ийн баталгаажсан ноолуурын хэмжээг хамгийн багадаа тухайн бүтээгдэхүүний **нийт ноолуурын 33%** мөн **нийт материалын 5%** байх ёстой гэж тогтоосон.

Энэхүү журмын дагуу эцсийн бэлэн бүтээгдэхүүнд ТННЭ-ийн баталгаажсан ноолуурын хэмжээ 5%-100% байх боломжтой гэсэн үг юм. Энэ нь ТННЭ-ийн гишүүдэд өөрсдийн нийлүүлэлтийн сүлжээ, үйлдвэрлэлийн онцлог, чанарын шаардлага зэрэгт нийцүүлэн 5% дээш баталгаажсан ноолуурын ямарч агууламжтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх уян хатан нөхцөл бүрдүүлнэ.

**ТННЭ-ийн
баталгаажсан
ноолуурыг зөвхөн ээрэх
шатнаас бусад
ноолууртай холино.
Нэгж бүтээгдэхүүнд**

**ТННЭ-ийн
баталгаажсан
ноолуурын хэмжээ
хамгийн багадаа
тухайн бүтээгдэхүүний
нийт ноолуурын 33%
мөн нийт материалын
5% байх ёстой.**



Мөшгөлтийн тогтолцоо



2. ТННЭ-ийн БАТАЛГААЖУУЛАЛТ



Одоогийн байдлаар ТННЭ-нь бэлтгэн нийлүүлэгч малчдын байгууллага болон анхан шатны боловсруулах үйлдвэрүүдэд “ТННЭ-ийн Ноолуурын Стандарт”-ын дагуу баталгаажуулалт явуулж байна.

Бид бэлтгэн нийлүүлэгч малчдын байгууллагад: “**Мал аж ахуй эрхлэх, ноолуур бэлтгэх**” ба “**Бэлчээр зохистой ашиглах**” зохистой дадлын стандартыг, боловсруулах үйлдвэрт: “**Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал**”-ын стандартыг ноолуур угаах ба самнах процесс дээр нэвтрүүлж байна.

ТННЭ-ээс баталгаажуулалт авахын тулд бэлтгэн нийлүүлэгч малчдын байгууллага болон анхан шатны боловсруулах үйлдвэрүүд холбогдо зохистой дадлын хамгийн бага шалгуурт нийцэж Хүрэл гэрчилгээний тохиролд нийцсэн байх шаардлагатай.

2.1. Бэлтгэн нийлүүлэгч малчны байгууллага

ТННЭ-д бүртгүүлсэн малчдын байгууллагад ТННЭ-ийн “Мал аж ахуй эрхлэх, ноолуур бэлтгэх зохистой дадал” болон “Бэлчээр ашиглах зохистой дадал”-ын нийт 14 багц 100 гаруй шалгуур, шаардлагын дагуу тохирлын үнэлгээ хийгддэг. Тэдгээрийн дагадаг байдлын нотолгоонд үндэслэн зохистой дадлын тохирлыг хувь хэмжээгээр хүрэл, мөнгө эсвэл алтан гэрчилгээ олгодог.

Бэлтгэн нийлүүлэгч малчдын байгууллага нь ул мөрийн мөшгөлтөд эдгээр хоёр зохистой дадалд нийцэж батламжлал авсан тохиолдолд хамрагдах боломжтой.

Малчдын байгууллага “Мал аж ахуй эрхлэх, ноолуур бэлтгэх” болон “Бэлчээр ашиглах зохистой дадал”-ын шалгуурт нийцсэн тохиолдолд ноолуураа “ТННЭ-ийн баталгаажсан” хэмээн ноолууртай холилгүй боловсруулсан ноолуурыг “ТННЭ-ийн баталгаажсан ноолуур” гэнэ.

2.2. Анхан шатны боловсруулах үйлдвэр

ТННЭ-д бүртгэлтэй анхан шатны ноолуур боловсруулах үйлдвэр (үүнд угаах, самнах үйлдвэр орно) нь “**Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал**”-ын шаардлагын хамгийн багадаа Хүрэл батламжлалын тохиролд нийцсэн байх шаардлагатай.

 Угаах үйлдвэр нь ноолуураа зөвхөн ТННЭ-ийн батламжлалтай малчдын байгууллагуудаас (“Бэлчээр ашиглах” болон “Мал аж ахуй эрхлэх зохистой дадал”-ын дүрэмд нийцсэн малчдын байгууллагууд гэсэн үг) авсан тохиолдолд “ТННЭ-ийн баталгаажсан ноолуур” гэж тэмдэглэж болно

 Самнах үйлдвэр нь “**Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал**”-ын дүрэмд нийцсэн угаах үйлдвэрээс түүхий эдээ авсан тохиолдолд “ТННЭ-ийн баталгаажсан ноолуур” гэсэн мэдэгдэл гаргах боломжтой болно.

 Холимог буюу угаах, самнах үйлдвэрүүд нь дээрх шаардлагын аль алинд нь нийцсэн тохиолдолд ноолуураа “ТННЭ-ийн баталгаажсан ноолуур” мэдэгдэл гаргах боломжтой болно.

ТННЭ-ийн баталгаажсан малчдын байгууллагаас эх үүсвэртэй түүхий ноолуурыг “Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал”-ын шаардлага хангасан анхан шатны боловсруулах үйлдвэрт бусад

ноолууртай холилгүй боловсруулсан ноолуурыг “ТННЭ-ийн баталгаажсан ноолуур” гэнэ.

3. МӨШГӨЛТӨД ОРОЛЦОХ ШААРДЛАГААСАН НАМНААГАА

2021 онд мөшгөлтөд оролцох хүсэлтэй малчдын байгууллага, анхан шатны боловсруулах үйлдвэр, брэндүүд, жижиглэнгийн худалдаа эрхлэгчдийн шалгур:

Малчдын байгууллага нь 1) Мал аж ахуй, ноолуур бэлтгэх зохистой дадал болон 2) Бэлчээр ашиглах зохистой дадлын шаардлагуудад нийцсэн байх



Анхан шатны боловсруулах үйлдвэрүүд нь: 1) Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадлын шалгууруудад нийцсэн байх; 2) ТННЭ-д бүртгүүлсэн байх; 3) Гишүүнчлэлийн хураамжаа төлсөн байх



Эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нь 1) ТННЭ-д бүртгүүлэх; 2) Гишүүнчлэлийн хураамжаа төлсөн байх



Брэнд/жижиглэн худалдаа эрхлэгч нь заавал ТННЭ-ийн гишүүн байх




Оролцогч талууд энэхүү гарын авлагыг дагаж мөрдөх ба шаардлагатай тохиолдолд мөшгөлтийн аудитын зардлыг гаргах



Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаниуд мөшгөх тогтолцоонд оролцож энэхүү г авлагыг дагаж мөрдсөнөөр хариуцла үйлдвэрлэсэн ноолуур ашиглаж буйгаа хар боломжтойгоос гадна бүтээгдэхүүн дээрээ Certified" буюу "ТННЭ-ийн баталгаажсан" лого хэрэглэх боломжтой.



3. SFA Traceability System



Нэгдүгээр хэсэг:

Монгол дахь
компаниуд

- Бүх оролцогчид мөшгөх тогтолцооны аудитад орж баталгаажсан байх ёстой
- Монгол Улсад хийгдэж буй бүх ноолуурын арилжаа ТННЭ-ийн мөшгөлтийн дагуу хийгдэх бөгөөд ТННЭ-ээр баталгаажсан байна.

ТННЭ-ийн мөшгөх тогтолцоо

Хоёрдугаар хэсэг:

Гадаад компаниуд

ТННЭ-ийн мөшгөх тогтолцоо

Агууламжийн мэдэгдлийн стандарт

- Баталгаажсан ноолуурыг Монголд угааж, самнасан байх шаардлагатай бөгөөд гадаадын компаниуд самнасан ноолуурыг боловсруулах үйлдвэрээс шууд худалдан авах боломжтой болно.
- ТННЭ-ийн бүртгэлтэй Монгол болон гадаадын компанийн хооронд арилжаа хийгдсэн тохиолдолд уг арилжаа ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоонд хамрагдаж, баталгаажна.
- Монголоос гадна хийгдэх арилжаа (гадаадын 2 компанийн хооронд хийгдэх арилжаа) нь Агууламжийн мэдэгдлийн стандартын дагуу явагдаж, баталгаажуулалтын байгууллагаар хянаагдан баталгаажна.

Мөшгөх тогтолцоо гэдэг нь ТННЭ-ийн баталгаажсан ноолуурын нийлүүлэлтийн сүлжээнд дэх ул мөрийг бүхэлд нь мөшгөж, бүртгэл хөтлөх үйл явц юм.

Мөшгөлтийн тогтолцоог 2 хэсэгт хуваана. **Нэгдүгээр дүгээр хэсэгт** Монгол Улсад хийгдэж буй эсвэл Монгол компанийтай хийж буй бүх ноолуурын арилжааг ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцооны дагуу бүртгэн баталгаажуулна. Цаасан баримт болон цахим мөшгөлтийн тогтолцоог ашиглахаас гадна мөшгөлтөд оролцож буй компаниуд ноолуурын бүртгэл, архивлалт, хяналт зэрэг компанийн бүртгэлийн тогтолцоог энэхүү удирдамжид бүрэн нийцүүлсэн байна.

Мөшгөлтийн нэгдүгээр хэсэг (Part 1) Ноолуур нийлүүлэгчээс болон арилжаа эрхлэгчээс хүлээн авсан түүхий ноолуурыг боловсруулах үйлдвэр анхан шатны боловсруулалт хийж самнасан ноолуур гарна.

Хоёрдугаар хэсэг: Гадаад компаниудын хооронд хийгдэх бүх арилжааг Агууламжийн мэдэгдлийн стандартын дагуу мөшгөн баталгаажуулна.

Нэгдүгээр хэсэгт түүхий ноолуурыг малчдын байгууллагаас худалдан авч, тээвэрлэн анхан шатны боловсруулах үйлдвэрт угааж самнах дамжлагад орно. Мөн, ноолуур ээрэх, сүлжих, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэрэг үе шат Монголд хийгдэх тохиолдолд эдгээр үе шат бүгд Нэгдүгээр хэсэгт хамрагдаж ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоогоор баталгаажна.

Баталгаажсан ноолуурыг ЗӨВХӨН ээрэх шатнаас баталгаажуулаагүй ноолууртай холино. Компаниуд өөрсдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх онцлогоос шалтгаалан ээрэх эсвэл нэхэх шатнаас баталгаажсан ноолуурыг баталгаажаагүй ноолуур эсвэл бусад ширхэгтэй холих боломжтой. Нэгж бүтээгдэхүүн дэх баталгаажсан ноолуурын агууламжийн шаардлагыг (Нэгдүгээр бүлэгт заасан) мөрдсөн байх ба үйлдвэрлэлийн явцад баталгаажсан ноолуурын орцын хувь хэмжээг нарийн, үнэн зөв бүртгэсэн байх шаардлагатай.

4.1. Борлуулалтын баримт

Мөшгөлтийн тогтолцоонд хамрагдаж буй байгууллага ноолуур арилжих бүртээ борлуулалтын баримт заавал ашиглах бөгөөд борлуулалтын тухай мэдээллийг үнэн зөв оруулсан байх шаардлагатай. Борлуулалтын баримтын хувийг ТННЭ-д илгээн баталгаажуулна. Борлуулалтын баримт дараах мэдээллийг агуулна:

1. Борлуулалтын баримтын дугаар
2. Худалдан авагч ба Худалдагч мэдээлэл болох компанийн нэр, ТННЭ-ийн бүртгэлийн дугаар
3. Бүтээгдэхүүний мэдээлэл болох ноолуурын өнгө, хэмжээ, үнэ зэрэг багтана.

Хэвлэмэл (З өнгийн цаасан) борлуулалтын баримтыг малчдын байгууллага ба арилжаа эрхлэгч, анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийн хоорондын арилжаанд хэрэглэнэ. Бүрэн бөглөсөн борлуулалтын баримтын мэдээллийг ТННЭ-ийн цахим бүртгэлийн Сэйлсфорс (*Salesforce*) програм хангамж руу худалдан авагч шивж, борлуулалтын баримтын фото зурагийг хавсаргана.

Анхан шатны боловсруулалтаас хойших ноолуурын арилжаанд цахим борлуулалтын баримт олгох бөгөөд тавигдах шаардлага дээрхтэй ижил байна.

Борлуулалтын баримт 1 (цаасан): Орон нутгаас ноолуур авах үед бөглөнө

Борлуулалтын баримт 2 (цахим): Самнасан ноолуурыг ээрэх үйлдвэрт зарах үед бөглөнө

Борлуулалтын баримт 3 (цахим): Ээрмэл утас худалдан авч эцсийн хийх тохиолдолд бөглөнө.

4.2. Борлуулалтын гэрчилгээ

Цахим бүртгэлийн Сэйлсфорс програм хангамжид худалдан авагчийн шивж оруулсан ноолуурын хэмжээ болон бусад арилжааны мэдээллийг ТННЭ борлуулалтын баримт тус бүртэй тулган тохирч буй эсэхийг хянан үзнэ.

Борлуулалтын баримтыг хянаж үзээд зөрчилгүй тохиолдолд тухайн ноолуур эсвэл ноолууран бүтээгдэхүүнийг баталгаажуулж Монгол дахь ТННЭ-аас Борлуулалтын гэрчилгээг (загварыг Хавсралтаас үзнэ үү) цахимаар илгээх болно.

Борлуулалтын гэрчилгээ нь нийлүүлэлтийн сүлжээн дэх баталгаажсан ноолуурын хувь хэмжээний талаарх үнэн зөв мэдээллийг олгодог. Арилжаа эрхлэгчид, компани, үйлдвэрүүд Борлуулалтын гэрчилгээг баталгаа болгон ТННЭ-ээр баталгаажсан ноолуурыг борлуулж болно.

4.3. Бүртгэл хөтлөх

ТННЭ-ийн мөшгөлтийн дотоод мэдээллийн сангаас гадна 2021 оны мөшгөлтөнд оролцож буй талууд ТННЭ-ийн баталгаажсан ноолуурыг өөрсдөө давхар бүртгэн баримтжуулах үүрэгтэй.

Энэ нь тухайн арилжаа эрхлэгч, үйлдвэр, компанийн мөрдөж буй мөшгөх, бүртгэх, баримтжуулах дотоод дүрэм журам, тогтолцооны дагуу явна. Ингэснээр бид ТННЭ-ийн мөшгөлтийг оролцогч талын мөшгөлт, бүртгэлтэй харьцуулах улмаар ТННЭ-ийн мөшгөлтийн тогтолцоог сайжруулж боловсронгуй болгох боломж бүрдэх юм.



Борлуулалтын баримт, борлуулалтын гэрчилгээг Хавсралт хэсгээс харна уу.



5. МЭДЭГДЭЛ ГАРГАХ

2021 оны мөшгөлтөд оролцогч талууд өөрсдийн бүтээгдэхүүн дээр ТННЭ-ийн баталгаажсан ноолуурын агууламжийн талаар мэдэгдлийг хэрхэн хийх тухай доорх хүснэгтээр үзүүлэв. Нийлүүлэлтийн үе шатаас хамаарч ТННЭ-ийн баталгаажсан ноолуурын мэдэгдлийг дараах байдлаар гаргана.

МӨШГӨЛТӨД ОРОЛЦОГЧ ТАЛ	МЭДЭГДЭЛ ГАРГАХАД ТАВИГДАХ НӨХЦӨЛ	МЭДЭГДЭЛД БИЧИХ ТЕКСТ
Бэлтгэн нийлүүлэгч Малчдын Байгууллага	<ul style="list-style-type: none">▪ ТННЭ-ийн бүртгүүлсэн байх▪ “МАА эрхлэх” ба “Бэлчээр ашиглах зохистой дадал”-ын тохирлын үнэлгээнд хамрагдаж, гэрчилгээтэй байх	<p>“Манайх ТННЭ-ийн хүрэл/мөнгөн/алтан баталгаажилттай бэлтгэн нийлүүлэгч малчдын байгууллага”</p>
Арилжаа эрхлэгч	<ul style="list-style-type: none">▪ ТННЭ-д бүртгүүлсэн байх▪ ТННЭ-ийн баталгаажсан ноолуурыг зайлшгүй “Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал”-ыг нэвтрүүлж буй анхан шатны үйлдвэрт борлуулах▪ ТННЭ-ийн баталгаажсан ноолуурыг нээлттэй зах зээлд ТННЭ-д мэдэгдэлгүйгээр борлуулж болохгүй	<p>“Манайх ТННЭ-д бүртгэлтэй ноолуурын арилжаа эрхлэгч байгууллага”</p> <p>Түүхий ноолуурыг “ТННЭ-ийн баталгаажсан ноолуур” гэж зөвхөн мөшгөлтөнд оролцох эрхтэй үйлдвэрт борлуулж болно</p> <p>Самнасан ноолуурыг “ТННЭ-ийн баталгаажсан ноолуур” гэж зөвхөн мөшгөлтөнд оролцох эрхтэй үйлдвэрт борлуулж болно</p>
Анхан шатны боловсруулах үйлдвэр	<ul style="list-style-type: none">▪ ТННЭ-д бүртгүүлсэн байх▪ Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадлыг нэвтрүүлсэн байх, тохирлын үнэлгээнд хамрагдсан байх, Мөшгөлтийн аудит хийгдсэн байх▪ ТННЭ-ийн баталгаажсан ноолуурыг нээлттэй зах зээлд ТННЭ-д мэдэгдэлгүйгээр борлуулж болохгүй	<p>“Манайх ТННЭ-ийн хүрэл/мөнгөн/алтан баталгаажилттай боловсруулах үйлдвэр”</p> <p>Самнасан ноолуурыг “ТННЭ-ийн баталгаажсан ноолуур” гэж зөвхөн мөшгөлтөнд оролцох эрхтэй үйлдвэрт борлуулж болно</p>
Эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	<ul style="list-style-type: none">▪ Компанийн мэдээлэл ТННЭ-ийн мэдээллийн санд бүртгэгдсэн байх▪ ТННЭ-ийн Мөшгөлтийн аудит хийгдсэн байх▪ ТННЭ-ийн баталгаажсан ноолуур агуулсан бүтээгдэхүүнийг зөвхөн мөшгөлтөнд оролцох эрхтэй компанийд борлуулах	<p>“Энэ бүтээгдэхүүнд ТННЭ-ийн баталгаажсан ноолуурын агууламж X%” (%-ийг тодорхой заана)</p>
Брэнд, худалдаа эрхлэгч	<ul style="list-style-type: none">▪ ТННЭ-ийн гишүүнчлэлтэй байх▪ Брэндууд өөрсдийн бүтээгдэхүүнээ борлуулах	<p>“Энэ бүтээгдэхүүнд ТННЭ-ийн баталгаажсан ноолуурын агууламж X%” (%-ийг тодорхой заана)</p> <p>Бэлэн бүтээгдэхүүний шошго дээр “SFA Certified” лого байрлуулж болно.</p>

6. БАЙГУУЛЛАГУУДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Энэ бүлэгт ул мөрийг мөшгөх тогтолцоонд оролцох компаниудад ТННЭ-ийн баталгаажсан ноолуур болон ноолууран бүтээгдэхүүн арилжаалахад тавигдах шаардлагууд мөн боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцад баталгаажсан ноолуурыг хэрхэн ялган ангилах, холих талаар тусгав.

Оролцогч бүх тал ТННЭ-ийн гишүүн байх ёстой. Гишүүн биш тохиолдолд бүртгэлийн маягт бөглөж, гишүүнчлэлийн хураамж төлөн албан ёсоор бүртгүүлэх шаардлагатай. Брэнд болон жижиглэн худалдаа эрхлэгчид ч мөн адил гишүүн байх ёстой

ТННЭ-ийн баталгаажсан ноолуур, ноолууран бүтээгдэхүүн арилжаалах хүсэлтэй аливаа этгээд Мөшгөлтийн тогтолцооны шаардлагыг ханган энэхүү гарын авлагыг дагаж мөрдөх ёстой

6.1. Бичиг баримт хөтлөх, журам боловсруулах, ажилчдаа сургах, бусад үүрэг хариуцлага

6.1.1 Тухайн оролцогч компани нь ТННЭ-ийн мөшгөлтийн удирдамжаар тавигдаж буй шаардлагуудыг өөрийн дүрэм журамд тусгасан байх үүрэгтэй.

6.1.2 ТННЭ-ийн энэхүү мөшгөлтийн удирдамжийг хэвлэн бэлэн байлгах шаардлагатай.

6.1.3 ТННЭ-ийн удирдамжид заасан арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх ажилтан (ажилтнууд)-г томилсон байх бөгөөд тухайн ажилтан зохих сургалтанд хамрагдаж шаардлагатай үр чадвар эзэмшсэн байна.

6.1.4 Мөн менежментийн төвшинд ТННЭ-ийн ул мөрийн мөшгөлтийг тухайн байгууллагын өөрийн мөшгөлт/ бүртгэлд хариуцаж нэвтрүүлэх удирдах албан тушаалтныг томилсон байна.

6.1.5 ТННЭ-ээр баталгаажсан ноолуурыг баталгаажаагүй ноолуураас ангилан салгаж, угаах, самнах үе шатанд зайлшгүй бүрэн тусгаарлах шаардлагатай.

хольж болно (өөр өөр малчдын байгууллагын).

6.1.7 Тухайн анхан шатны боловсруулах үйлдвэр нь ТННЭ-ээр баталгаажсан ноолуурын өдөр тутмын дамжлагын бүртгэлийг тогтмол бүртгэж явах шаардлагатай.

6.1.8 Ул мөрийг мөшгөх тогтолцооны сургалт явуулсан баримт бичгийг 5 жил хадгалах үүрэгтэй бөгөөд ТННЭ-ээс аудит орох үед аудиторт шалгуулах шаардлагатай.

Энэхүү удирдамжид заасан зүйлүүдтэй холбоотой ямар нэгэн тодруулах, нэмэлт тайлбар авах, өөрчлөлт оруулах, мөн гомдол санал гэх зэрэг зүйл гарвал ТННЭ-ийн мэргэжилтнүүдтэй холбогдох бөгөөд

Feedback@sustainablefibre.mn цахим хаягт илгээх боломжтой. ТННЭ нь ирсэн саналыг харгалzan Гомдол барагдуулах журамын дагуу ажлын 10 хоногт шийдвэрлэнэ.

6.1.9 ТННЭ-ээр баталгаажсан самнасан ноолуурыг экспортлоход Монгол Улсын холбогдох хууль, дүрэм, журмыг баримтлана.

6.1.10 Ээрэх дамжлага хүртэл баталгаажсан ноолуурыг баталгаажаагүй ноолууртай хольж ул болно. Ээрэх дамжлагаас хольж болох бөгөөд баталгаажсан ноолуурын агууламжийг нарийн хянан бүртгэн баримтжуулна.

6.1.11 Нэгж бүтээгдэхүүнд ТННЭ-ийн баталгаажсан ноолуурын хэмжээг хамгийн багадаа тухайн бүтээгдэхүүний **нийт ноолуурын 33%** мөн **нийт материалын 5%** байх ёстой. Энэ нь эцсийн бүтээгдэхүүн дэх баталгаажсан ноолуурын хэмжээ 5%-100% хооронд байх боломжтой гэсэн үг бөгөөд тухайн бүтээгдэхүүн дэх хэмжээг нарийн тогтоосон байх шаардлагатай. Доор жишээн дээр тайлбарлав:

ЖИШЭЭ 1:

Хэрвээ 100% ноолуурган ороолт үйлдвэрлэвэл хамгийн багадаа 33% нь ТННЭ-ээр баталгаажсан ноолуур байх ёстой

ЖИШЭЭ 2:

Хэрвээ 70% торго ба 30% ноолуурган ороолт үйлдвэрлэвэл ноолуурт агуулагдах ТННЭ-ийн баталгаажсан ноолуурын агууламж хамгийн багадаа 33% буюу ороолтны нийт материалын 10% (=33% x 30%) байх ёстой

ЖИШЭЭ 3:

Хэрвээ 95% ноос ба 5% ноолуурган ороолт үйлдвэрлэвэл энэхүү 5% ноолуур бүхэлдээ ТННЭ-ээр баталгаажсан ноолуур байх ёстой

үйлдэнэ. (Өмнөх арилжааны Борлуулалтын гэрчилгээг шалгаж болно).

6.2.2 Баталгаажсан ноолуурын хэмжээг борлуулалтын баримттай зайлшгүй тулгаж, хянан шалгасны дараа бүртгэж авна.

6.3 Түүхий эдийн гаралтын бүртгэл

6.3.1 ТННЭ-ийн баталгаажсан ноолуур агуулсан бүтээгдэхүүнийг борлуулахад хоёр талын гарын үсэг зурж баталгаажуулсан борлуулалтын баримт зайлшгүй дагалдуулах шаардлагатай

6.3.2 Ямар малчдын байгууллагаас ноолуур нийлүүлсэнийг мэдэхийн тулд борлуулалтын баримтын арын нүүрэнд малчдын байгууллагын ТННЭ-ээс олгосон бүртгэлийн дугаарыг бичнэ.

Ноолуур болон ноолуурган бүтээгдэхүүнээ худалдаалах болгонд борлуулалтын баримт зайлшгүй дагалдана.

6.3.3 Тухайн компанийн худалдаж буй баталгаажсан ноолуурын хэмжээ худалдан авсан ноолуурын хэмжээтэй (гарцын хувийг тооцоход) дүйцэж байх шаардлагатай.

6.3.4 Ноолуур болон ноолуурган бүтээгдэхүүнийг экспортонд гаргахад холбогдох хууль, дүрэм журмыг баримтална.

Мөшгөлтөнд оролцогч компаниуд нь өөрсдийн гарцын хувийг тооцоолж байгаа зарчмыг 6.1.1-д заасан журмын хавсралтаар оруулсан байх

Компаниуд энэхүү удирдамжийн **5 дугаар бүлэгт** заасан ул мөрийг мөшгөх тогтолцооны мэдэгдлийн бүдүүвчийг дагаж мөрдөнө.

Тухайн бүтээгдэхүүний мэдэгдэлд ТННЭ-ийн баталгаажсан ноолуурын агууламжийн **хувь хэмжээг тодорхой заах** (жишээ нь, 100% гэх) эсхүл ТННЭ-ийн баталгаажсан ноолуурын агууламж **хамгийн багадаа X%** (жишээ нь, хамгийн багадаа 33%) гэж заана.

ТННЭ-ийн баталгаажсан ноолуур агуулсан эцсийн бэлэн бүтээгдэхүүнд (хэрэв ТННЭ-тэй өөрөөр тохиролцоогүй бол) **“SFA Certified”** хэмээх шошго зүссэн байх ёстой.

Брэнд/жижиглэнгийн борлуулалт эрхэлдэг компаниудын худалдаж авсан болон борлуулж буй баталгаажсан ноолуур агуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ зөрөхгүй тулж байх ёстой.

Компаниуд ТННЭ-ийн гишүүн бус брэнд худалдан авагчдад ТННЭ-ээр баталгаажсан ноолуур санал болгохгүй. Зөвхөн ТННЭ-ийн гишүүн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд ТННЭ-ээр баталгаажсан бүтээгдэхүүн санал болгох эрхтэй.



ТННЭ-ийн баталгаажсан ноолуур агуулж буй эцсийн бүтээгдэхүүний мэдэгдэлд гаргах зааварчилгаа, логонд тавигдах шаардлага зэргийг ТННЭ-ээс брэнд болон жижиглэнгийн борлуулалт эрхэлдэг компаниудад өгнө.

ТННЭ-д бүртгэлгүй компанийд “SFA Certified” бүтээгдэхүүн санал болгохыг хүсвэл ТННЭ-д хандах шаардлагатай бөгөөд бид тухайн компанийг бүртгэн авч зохих удирдамжаар хангах болно.

8. ХАВСРАЛТ

8.1 ТННЭ-ийн Монгол дахь оффистой холбоо барих хаяг

ENGLISH

The Sustainable Fibre Alliance
Room #32, 2nd floor, Grand Office
Olympic Street,
Ulaanbaatar, Mongolia
Tel: +976-70115559

email: admin@sustainablefibre.mn

Монгол

Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Олимпийн гудамж
Гранд оффис, 23 тоот

и-мэйл: admin@sustainablefibre.mn

8.2 Борлуулалтын баримт

ББ 1: (Түүхий ноолуураас самнасан ноолуур хүртэлх арилжаанд ашиглана)

PHASE 1 TRANSACTION RECEIPT 1 (RAW TO DEHAIR)			
Date [DD/MM/YYYY]: / / Transaction Receipt #:			
Historical Receipt Numbers for fibre contained in this batch:			
1. BUYER DETAILS		2. SELLER DETAILS	
Company Name:		Company / Organisation Name:	
Type of Buyer (tick all that apply): <input type="checkbox"/> Trader <input type="checkbox"/> Processor <input type="checkbox"/> Manufacturer <input type="checkbox"/> Brand/retailer		Type of Seller (tick all that apply): <input type="checkbox"/> Producer Organisation <input type="checkbox"/> Trader <input type="checkbox"/> Processor	
SFA Register ID:		SFA Register ID:	
Contact email:		Contact email:	
Contact number:		Contact number:	
3. PRODUCT DESCRIPTION			
Product Type (tick one): <input type="checkbox"/> Raw <input type="checkbox"/> Scoured			
Colour	Weight (KG)	Price per KG (MNT)	Total price per colour (MNT)
Mixed			
White			
Grey			
Brown/Dark			
TOTAL WEIGHTS		TOTAL PRICE	
Buyer Representative Name:		Seller Representative Name:	
Signature:		Signature:	
White Copy = SFA; Pink Copy = Seller, Yellow Copy = Buyer			
SFA Mongolia Office: Room #32, 2 nd floor, Grand Office, Olympic Street, Ulaanbaatar. Tel +976-70115559			

ББ 2: (Самнасан ноолуураас ээрэх хүртэлх арилжаанд ашиглана)

PHASE 2 ELECTRONIC TRANSACTION RECEIPT 2 (DEHAIRDED TO SPUN YARN)



Date: [DD/MM/YYYY] Transaction Receipt #: [enter receipt number here]

Historical Receipt Numbers for fibre contained in this batch: [enter historical receipt numbers here]

1. BUYER DETAILS		2. SELLER DETAILS		
Company Name: [enter name here]		Company Name: [enter name here]		
Type of Buyer (tick all that apply): <input type="checkbox"/> Trader <input type="checkbox"/> Processor <input type="checkbox"/> Manufacturer <input type="checkbox"/> Brand/retailer		Type of Seller (tick all that apply): <input type="checkbox"/> Trader <input type="checkbox"/> Processor <input type="checkbox"/> Manufacturer <input type="checkbox"/> Brand/retailer		
Contact email: [enter email here]		Contact email: [enter email here]		
Contact number: [enter phone number here]		Contact number: [enter phone number here]		
3. PRODUCT DESCRIPTION				
Product Type (tick one): <input type="checkbox"/> Yarn <input type="checkbox"/> Fabric <input type="checkbox"/> Final product				
Description	Batch ID numbers	Total Weight (KG)	SFA Content Weight (KG)	Proportion of SFA Content
[Description]	[#]	[#]	[#]	[#]
[Description]	[#]	[#]	[#]	[#]
[Description]	[#]	[#]	[#]	[#]
[Description]	[#]	[#]	[#]	[#]
TOTAL WEIGHTS		[#]	[#]	[#]
Buyer Representative Name: [enter name]		Seller Representative Name: [enter name]		
Signature:		Signature:		

Seller to secure signatures and send completed receipt to the SFA Mongolia Office: admin@sustainablefibre.mn

ББ 3: Part 2 (Ээрмэл утаснаас бэлэн бүтээгдэхүүн хүртэлх арилжаанд ашиглана)

PHASE 2 ELECTRONIC TRANSACTION RECEIPT 3 (YARN ONWARDS)



Date: [DD/MM/YYYY] Transaction Receipt #: [enter receipt number here]

Historical Receipt Numbers for fibre contained in this batch: [enter historical receipt numbers here]

1. BUYER DETAILS		2. SELLER DETAILS		
Company Name: [enter name here]		Company Name: [enter name here]		
Type of Buyer (tick all that apply): <input type="checkbox"/> Trader <input type="checkbox"/> Processor <input type="checkbox"/> Manufacturer <input type="checkbox"/> Brand/retailer		Type of Seller (tick all that apply): <input type="checkbox"/> Trader <input type="checkbox"/> Processor <input type="checkbox"/> Manufacturer <input type="checkbox"/> Brand/retailer		
Contact email: [enter email here]		Contact email: [enter email here]		
Contact number: [enter phone number here]		Contact number: [enter phone number here]		
3. PRODUCT DESCRIPTION				
Product Type (tick one): <input type="checkbox"/> Yarn <input type="checkbox"/> Fabric <input type="checkbox"/> Final product				
Description	Batch ID numbers	Total Weight (KG)	SFA Content Weight (KG)	Proportion of SFA Content
[Description]	[#]	[#]	[#]	[#]
[Description]	[#]	[#]	[#]	[#]
[Description]	[#]	[#]	[#]	[#]
[Description]	[#]	[#]	[#]	[#]
TOTAL WEIGHTS		[#]	[#]	[#]
Buyer Representative Name: [enter name]		Seller Representative Name: [enter name]		
Signature:		Signature:		

Seller to secure signatures and send completed receipt to the SFA Mongolia Office: admin@sustainablefibre.mn

8.3 Борлуулалтын гэрчилгээ

 <p>ТОГТВОРТОЙ НООС НООЛУУРЫН ЭВСЭЛ</p>		Transaction Certificate Number: <div style="border: 1px solid black; padding: 2px; text-align: center;">TC000001</div>	
BUYER DETAILS Company Name: Type of Buyer (tick all that apply): <input type="checkbox"/> Trader <input type="checkbox"/> Processor <input type="checkbox"/> Manufacturer <input type="checkbox"/> Brand/retailer SFA Register ID: Contact number:		SELLER DETAILS Organisation/Company Name: Location of seller (town/city, province, country): SFA Register ID: Contact number:	
PRODUCT DESCRIPTION Fibre Type (Tick one): <input type="checkbox"/> Raw <input type="checkbox"/> Washed <input type="checkbox"/> Dehaired <input type="checkbox"/> Yarn <input type="checkbox"/> Fibre <input type="checkbox"/> Garment/Product			
ITEM DESCRIPTION		FIBRE TRANSACTION RECEIPT(S) / BATCH REFERENCE(S):	PRODUCT WEIGHT (KG)
TOTAL WEIGHT OF SFA CERTIFIED CASHMERE USED (KG)			
DECLARATION: This is to certify that the cashmere fibre purchased in the transaction above has been produced in accordance with the SFA's Cashmere Standard.			
ISSUER STAMP	ISSUER DETAILS  Тогтвортой ноос ноолуурлын эвсэл <i>Ноолуурлын өртгийн сүлжээний тогтвортой байдалыг хөгжүүлэхийн төлөө</i>		
DATE ISSUED	CHECKED AND ISSUED BY: (name and role)	CHECKED AND ISSUED BY: (signature)	



Нийтлэсэн:

Тогтвортой ноос ноолуурын эвсэл (ТННЭ)

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл: <http://sustainablefibre.org>

<http://sustainablefibre.mn>

Холбоо барих имэйл: info@sustainablefibre.org